

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ 2020 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2020.09.7

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлж, тайлагнах байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, Эх үүсвэр /Сая төгрөг/	Хэрэгжилт, үр дүн	Хувь
ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД							
<i>Хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллана.</i>							
114	4.1. Мал аж ахуй, газар тариалан	4.1.1 “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.	2017-2021	ХХААГ Сумдын Засаг дарга	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр-70.0 сая	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөг аймгийн засаг даргын 2017 оны А/46 дугаар захирамжаар батлуулан жил жилийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2017, 2018, 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай хангагдсан. 2020 онд 18 заалт бүхий төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж байна. Эхний 3-р улирлын хэрэгжилт 65 хувьтай.	70
115		4.1.2 Малчдыг мал, маллагааны арга ухаанд сургаж залуу халааг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.	2017-2020	ХХААГ ХХҮГ	Улсын төсөв -15.0	Илгээлтийн эзэд ба Залуу малчдын амжиргааг дэмжих хөтөлбөрийг боловсруулж Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/46 дугаар захирамжаар батлуулсан. МСҮТөвд мэргэжлийн малчны анги нээж 90 малчинг элсүүлж малын асаргаа сувилгаа, мэргэжлийн малчны ангид сургаж дадлагажуулж мэргэжлийн үнэмлэх олгосон. Мөн Монгол улсын зөвлөх мал зүйч, доктор, профессор Н.Сүхээг урьж 500 гаруй залуу малчдад мал маллах арга ухаан, байгалийн эрсдэлийг даван туулахад малчин хүний уламжлалт арга, өсвөр хээлтүүлэгчийг шилж сонгох, бэлчээрийг сэлгээтэй ашиглах, малын чанар, эрүүл мэндийг сайжруулах мэдлэг олгох сургалтаас	70

					гадна мал аж хуйн салбарт хэрэгжиж байгаа бодлого шийдвэрийг танилцууллаа. ХХҮГ-ын Малжуулах хөтөлбөрийн хүрээнд 2020 оны эхний 3-р улирлын дүнгээр онд 3 малчинг малжуулах төсөлд хамруулж 15,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 125 толгой мал худалдан аваад байна. Залуу малчдын тоо өмнөх оноос 1,9 хувиар өссөн.	
116		4.1.3 “Илгээлтийн эзэд” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2017-2020	ХХААГ	Илгээлтийн эзэд ба Залуу малчдын амжиргааг дэмжих хөтөлбөрийг 2017 онд батлуулан жил бүр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн үр дүнг тооцон ажиллаж ирлээ. 2017-2019 онуудад төлөвлөгөөг дунджаар 92,5% хувьтай хэрэгжүүлсэн. 2020 онд 8 заалт бүхий төлөвлөгөөг батлуулж 3-р улирлын байдлаар хэрэгжилт 75 хувьтай.	70
117		4.1.4 Бэлчээрийн даацад тулгуурлан мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.	2020	ХХААГ, ХОХБТХ Сумын ЗДТГ-ууд	Улсын төсөв 412.0 2020 онд бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх ажлын хүрээнд улсын төсвийн 300,0 сая төгрөгний хөрөнгөөр 60 тн бактержуулсан будааг 9 сумын 30,0 мян/га бэлчээрийн талбайд микробиологи, 10 сумын 70,0 га талбайд 112,0 сая төгрөгөөр энгийн механик аргаар тэмцэх ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэлийн үр дүн: Энгийн механик 84.6, микробиологи 84 хувь.	100
118		4.1.5 Тэмээний амьдын ашиг шим /ноос, сүү, уналгаа эдэлгээ/-ийг нэмэгдүүлж, тэмээгээ өсгөсөн сум баг малчдыг дэмжиж ажиллах.	2017-2020	ХОХБТХ ХХААГ, Сумдын ЗДТГ	Улсын төсөв 8.7 сая Хулд сумын “Олдохын хүрэн бор” тэмээг омог болгох ажлын хүрээнд 2020 онд 5000 тэмээнд үзлэг ангилалтын ажил хийсэн. Олдохын хүрэн бор тэмээний омгийн тодорхойлолтыг Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Их эрдмийн зөвлөлийн хурлаар дэмжигдсэн.	100
119		4.1.6 Аймгийн хэмжээнд жилдээ 10-аас доошгүй гүний худаг, 30-аас доошгүй	2016-2020	ХОХБТХ ХХААГ,	Төсөл-391.0 ОН-198.3 Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл төслийн	70

		гар худаг засварлах буюу шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг тогтмол нэмэгдүүлэн хяналт тавьж, нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг бэлчээрийн худагт суурилуулах.		Сумдын Засаг дарга		хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 27 худаг шинээр гаргах ажлын гүйцэтгэгчээр “Эхний эхэн”, “Гранд холдинг”, “Топ дриллинг” ХХК-иуд шалгарч гэрээ байгуулж 3-р улирлын байдлаар 18 худгийг ашиглалтад хүлээн авлаа. Мөн 10 сум орон нутгийн хөрөнгө оруулалтаар энгийн уурхайн 46 худгийг сэргээн засварласнаар нийт 400,5 мян/га бэлчээрийг усжуулах хийгдэж байна. Гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан “Топ дриллинг” ХХК гэрээний үүргээ зөрчсөний улмаас, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх гүн өрмийн 20 худгийг гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлагдан үнэлгээний явцдаа байна.	
120		4.1.7 Аймгийн хэмжээнд өндөр ашиг шимт сүүний чиглэлийн аж ахуйг хөгжүүлэн, малын тоог чанарт шилжүүлж, ашиг шим хүртээмжийг сайжруулах.	2017-2020	ХХААГ Сумдын Засаг дарга		Мах сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг аймгийн хэмжээнд 44 өрх 779 толгой үхэртэй, махны чиглэлийн аж ахуйг 3 өрх 50 толгойг тус тус эрхлээд явж байна. Сүүний чиглэлийн ямаа 3 өрхөд 194 толгой байна. Мах сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэх сонирхолтой 25 иргэнийг сургалтанд хамруулсан.	70
121		4.1.8 Гахай, шувууны туслах аж ахуйг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжих.	2017-2020	ХХААГ Сумдын Засаг дарга нар		Аймгийн хэмжээнд туслах аж ахуй эрхэлж байгаа 20 өрх байгаагаас 5 өрх 48 толгой гахайтай, 15 өрх 710 толгой тахиатай байна. 2019 онд гахайн мялзан гарсан тул гахай устгалд орсон. Эрсдэл өндөр тул аж ахуй эрхлэх сонирхолтой иргэд цөөн байна.	0
122		4.1.9 Цөм сүргийн үржлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин, нутгийн шилмэл болон гойд ашиг шимт малыг өсгөх, өөрийн аймгийн брэнд болсон омог, хэвшлийн малтай болох.	2017-2020	ХХААГ, Хулд сумын ЗДТГ	Улсын төсөв 12.5	Цөм сүргийн үржлийн аж ахуйг өргөжүүлэн ажилласнаар Өндөршил, Сайнцагаан сумдад үржүүлэгддэг Хурд-Махны чиглэлийн “Өндөршил” омгийн адуу, Мах-Өөх-Ноосны чиглэлийн “Сайнцагаан” омгийн хонийг тус тус бий болгосон.	70

						2020 онд Хулд сумын Олдохын хүрэн бор тэмээний омгийн тодорхойлолтыг Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнд хүргүүлж ажилласнаар Их эрдмийн зөвлөлийн хурлаар дэмжигдээд байна. Мөн ХХААХҮЯамны Сайдын 2020 оны А\232 тоот тушаалаар томилогдсон улсын хянан магадлагааны комисс хаврын үзлэг ангилалтыг 6 дугаар сард хийж, намрын үзлэг ангилалтыг 09 дүгээр сард хийхээр төлөвлөн хийгдэж байна. Омог баталгаажснаар орон нутгийн онцлогт тохирсон мал сүргийнхээ ашиг шимийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Зах зээл бэлчээрийн удирдлага төслийн болон орон нутгийн оролцооны хөрөнгөөр 15 сумын ХААТасаг, Мал үржлийн үйлчилгээний нэгжийг бод, бог малын палк метр, циркул метр, лентметрээр 100 хувь ханган, 2 сумыг бод, бог малын зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж тоног төхөөрөмжөөр хангаснаас гадна аймгийн хэмжээнд малд зохиомол хээлтүүлэг хийх явуулын пункт, бод мал жинлэх пүүг хүлээн авлаа.	
123		4.1.10 ХАА-н биржийн үйл ажиллагааг тогтмол явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, биржийн арилжааг орон нутагтаа хөгжүүлэх.	2016-2020	ХХААГ Сумдын Засаг дарга	Улсын төсөв 11. 000,0	2020 онд эрх бүхий Давших зам, Рашаантын аж богд, Амьдралын туг хоршоод нь хонины ноос 1351,6 тонн, тэмээний ноос 78,8 тонныг бэлтгэн үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан. Ноосны урамшуулалын авах материалыг ХХААХҮЯаманд хүргүүлээд байна. Улсын Их Хурлын 32, Засгийн газрын 167 дугаар тогтоолын дагуу 1,849,284 ямааны 554785,2 кг ноолуурт урамшуулал олгуулахаар	100

						материалыг хүргүүлсний үр дүнд 8592 малчин өрхөд 11 тэрбум төгрөг авлаа.	
124		4.1.11 Малын эмчийг орон нутаг тогтвор суурьшилтай ажиллуулах, мал эмнэлгийн үйлчилгээг эрхлэх боломжийг бүрдүүлэн материаллаг баазыг бэхжүүлж, үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг сайжруулах.	2017-2020	МЭГ Сумдын Засаг дарга	ОН-99.0 Төсөл -126.0	Аймгийн Мал эмнэлгийн газар нь 16 орон тоотойгоор, 15 суманд 10 байцаагч, 8 тархвар зүйч, нийт 34 орон тоотойгоор ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Мал эмнэлгийн хувийн 34 нэгжийн 43 малын эмчтэйгээр мал эмнэлгийн үйл ажиллагааг малчин, мал бүхий иргэдэд үзүүлж байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл төслийн болон орон нутгийн 180,0 сая төгрөгийн өртөг бүхий 12 ширхэг мал угаалгын ванн шинээр барих ажлыг 11 суманд хийж гүйцэтгэн хүлээн авах комисс томилогдоод байна.	70
125		4.1.12 Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бруцеллёз өвчинтэй тэмцэх стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.	2017-2020	МЭГ Сумдын Засаг дарга	Улсын төсөв- 210.0 ОН-140.0	Аймгийн Засаг даргын 2020 оны 4 сарын 30-ны өдрийн А/125 захирамжийн дагуу 4 сарын 25-ны өдрөөс 5 сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд Цагаандэлгэр, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Өндөршил, Өлзийт сумдад Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан. Дархлаажуулалтад 1727 өрхийн 19533 үхэр, 637851 толгой хонь, 561458 толгой ямаа нийт 1218862 толгой мал хамруулан 93%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. Дотрын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 607 өрхийн 183756 хонь, 92422 ямаа, 15593 хурга, 1321 ишиг бүгд 293092 толгой мал хамрагдсан. Шөвөг яраас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 242745 төл хамрагдсан.	70

						Сохор догол өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 13840 толгой мал хамрагдсан. Аймгийн Засаг даргын 7 сарын 29-ний өдрийн А/192 тоот захирамжийн дагуу 15 сумын хэмжээнд Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дархлаажуулалтанд 1383 өрхийн 3139 тугал, 167763 хурга, 122913 ишиг бүгд 290516 толгой төл хамруулан 53%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	
126		4.1.13 Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн оношилгооны чадавхыг үнэлэх магадлан итгэмжлэлийн зардал, халаалт дулааны сүлжээний асуудлыг шийдвэрлэж ажиллах нөхцөлийг дээшлүүлэх.	2017-2020	ХОХБТХ МЭГ	Улсын төсөв-31.4	МЭЛ-ын магадлан итгэмжлэлийг хугацааг сунгуулахаар Стандарт хэмжилзүйн газарт итгэмжлүүлэх хүсэлт өргөдөлийг холбогдох бичиг баримтын хамт хүргүүлсэн. Итгэмжлэлтэй холбоотой төлбөрийн зардалыг МЭЕГ-аар шийдүүлэн MNS ISO/IEC 17025-2018 стандарт, түүнтэй холбоотой бусад норматив техникийн баримт бичгүүдийг заасан шаардлагад нийцүүлэн бичиг баримтыг боловсруулж байна. МЭЛ-ийн уурын зуух, шугам сүлжээний зураг төсвийг хийлгэж, 31,4 сая төгрөгөөр уурын зуухны тогоог шинээр тавьж, газар доорхи зарим шугамыг сольж шинэчилсэн.	70
127		4.1.14 Дэрэн суманд байгуулагдсан тэжээлийн ургамал тариалах ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг өргөжүүлж, аймгийн тэжээлийн үрийн хэрэгцээг хангах.	2017-2020	ХХААГ Дэрэн сумын Засаг дарга	Хувийн хэвшил 5.0	Дэрэн суманд үйл ажиллагаа явуулж буй ЭШТҮОНӨААТҮГ газарт аймгийн ЗДТГ-ын захирамжаар томилогдсон 5 гишүүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хариуцагч М.Сосорбурамыг байлцуулан тооллогыг зохион байгууллаа. Хөрөнгийн тооллогоор: 1. Барилга байгууламж-125 461 300 төгрөг 2. Авто тээврийн хэрэгсэл-207 600 000 төгрөг	70

						3. Лабораторийн тоног төхөөрөмж-5 775 000 төгрөг 4. Лабораторийн эд хогшил-6 565 000 5. Хорголжин ба багсармал тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж-77 600 000 төгрөг 6. Бусад материал 40 084 000 төгрөгийн нийт 465085300 төгрөгний эд хөрөнгийг бүртгэж тоолов Дэрэн суманд овъёос, арвайг 10 га талбайд тариалсан, ургалтын явц 60 хувьтай байна.	
128		4.1.15 Онги голыг түшиглэн усалгаатай газар тариалангийн /төмс, хүнсний ногоо, чацаргана/ аж ахуй байгуулахыг дэмжих.	2017-2020	ХХААГ Сайхан-Овоо сумын Засаг дарга	Хувийн хэвшил 5.0	Сайхан-Овоо сум нь төмс 6 га-д, хүнсний ногоо 3 га-д, чацаргана 0,5 га-д тус тус тариалснаар өмнөх оноос 1,8 га –гаар нэмэгдсэн байна.	70
129		4.1.16 Өвлийн нарлаг хүлэмжийг байнгын ажиллагаанд оруулж, иргэд, байгууллага, аж ахуй нэгжийн хүнсний нарийн ногоо, жимс жимсгэний тариалалтыг дэмжих.	2017-2020	ХХААГ	Хувийн хэвшил 5.0	Аймгийн хэмжээнд 2020 онд өвлийн хүлэмжинд 1540м ² талбайд тариалалт хийснээр өмнөх оноос 67м ² , зуны 76 ш хүлэмжний 10046 м ² талбайд тариалалт хийснээр урьд оноос 1017м ² талбайгаар тус тус нэмэгдсэн.	70
130		4.1.17 Сумдын хилийн цэсийн маргааныг арилгах талаар бодитой арга хэмжээ авах.	2017-2020	ХОХБТХ ГХБХБГ		Харъяалах сумын нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна хороо бууц эзэмшдэг иргэдийн газрын асуудлыг шийдэх зорилгоор тухайн харъяалагдаж байгаа сумдад нь албан бичиг хүргүүлж 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан. 2020 оны 10-р сард холбогдох сумдаас судалгааг авч хүргүүлэхээр ажиллаж байна.	70

132	4.2. Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдаа	4.2.2 “Дундговийн мах”, “Дундговийн айраг” брэндийг баталгаажуулж, экспортыг дэмжиж, Улаанбаатар хотод худалдааны цэгтэй болох.	2017-2020	ХОХБТХ ХХААГ	Дундговь аймгийн Их хайрхан мандал” ХХК нь Нисэх, Яармагт мах худалдан борлуулах салбарыг нээж Улаанбаатар хотын хэрэглэгчдэд Дундговийн махыг тасралтгүй нийлүүлж байна. Эхний 8 сарын байдлаар 390 гаруй тн мах нийлүүлсэн байна Мөн Сайнцагаан сумын “Буянт өртөө” ХХК Сум хөгжүүлэх сангийн 30,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр “Мах ангилах хатаах үйлдвэр”-ийг ашиглалтанд оруулж мах шулагч, зөөгч, үйлчлэгч зэрэг 4 ажлын байрыг шинээр бий болгосон. Үйлдвэр нь борц хатаагч, вакумжуулагч, махны хөрөө, бандан, номераторын машин зэрэг тоног төхөөрөмжүүдийг суурилуулснаар 2018, 2019, 2020 онд тэмээ, үхрийн 15 тн махыг шулж борцлон хатааж зах зээлд нийлүүлжээ.	70
133		4.2.3 Сум бүр мал нядалгааны цэгтэй болж улмаар хүнсний захуудад орон тооны малын эмчийг тогтмол ажиллуулан эрүүл ахуйн шаардлагад нийцсэн махаар хүн амын хэрэгцээг тасралтгүй хангах.	2017-2020	ХОХБТХ, ХХААГ, Сумдын Засаг дарга нар	Сайнцагаан сумын ЭЭТМО ХХК мал нядлах нядалгааны цэгийн газрыг олгож дэмжлэг үзүүлснээр нэг удаадаа 1000-н толгой мал хаших хашаа, өдөрт 400 толгой мал, Их хайрхан мандал ХХК өдөрт 350 толгой мал, Говь-Угтаал сум өдөрт 120 мал нядлах хүчин чадалтай мал нядлах цэг, Ээлт мөнх наран ХХК иргэн Отгонцэцэг, Гантөмөр нар нь мах хадгалах 350 тн-ы хөргүүртэй зоорь тус тус ашиглалтад оруулж албан байгууллага, ард иргэдийн хэрэгцээнд махыг тасралтгүй нийлүүлж байна. Аймгийн төвийн хүнсний захад малын эмчийг тогтмол ажиллуулснаар худалдан борлуулж байгаа мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн болон сургууль, цэцэрлэгийн хоол хүнсэнд хэрэглэгдэж байгаа хүнсний	70

						бүтээгдэхүүнд хийгдэх шинжилгээг тогтмолжууллаа. ЖДҮХСангаас мах махан бүтээгдэхүүн боловсруулах цех байгуулах 1 иргэнд 70 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 80 тн махыг савлаж 400 сая төгрөгний борлуулалттай ажиллаж байна. 2020 онд ЖДҮХС-аас дээрхи чиглэлээр 8 аж ахуй нэгж 745,0 сая төгрөгийн зээл авахаар төсөл боловсруулан ирүүлээд байна.	
134		4.2.4 Аймгийн хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн үйлчилгээний төвийг байгуулах санаачилгыг дэмжих.	2017-2020	ХОХБТХ, ХХААГ, Сумдын Засаг дарга	Хувийн хэвшил- 50.0	Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт Жинд болор ХХК нь 850,0 сая төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаар 450м2 талбай бүхий худалдаа, үйлчилгээний барилгыг шинээр ашиглалтад оруулж, 12 ажлын байрыг шинээр бий болгон Улаанбаатар хотын “Номин трейд” ХХК-ны бараа бүтээгдэхүүнийг гэрээгээр борлуулан ажиллаж байна. Дээрхи хувийн хэвшлийн барилга барих газрын асуудлыг шийдвэрлэж, худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгох зэрэг дэмжлэгийг үзүүллээ.	100
135		4.2.5 Хоол, хүнс үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	2017-2020	ХОХБТХ, ХХААГ		Хүнсний худалдаа эрхлэгч, талх нарийн боов үйлдвэрлэгч иргэн ААНэгжүүдэд МХГазартай хамтран Цагаан сарын хэвийн боов үйлдвэрлэлтэй холбогдуулан Эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн зохистой дадал GMP, хаяг шошгын стандартын шаардлагыг мөрдүүлэх, чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүнд Хүнсний үйлдвэр цех 5, хоол үйлдвэрлэл-3, хүнсний худалдаа эрхлэгч 16 иргэн хамрагдсан байна. Мөн МХГазартай хамтран Хүнсний худалдаа эрхлэгч томоохон ААНэгжүүдийн менежерүүдэд	100

						худалдаалж буй Хүнсний зориулалтын болон зориулалтын бус хуванцар савны Олон улсад мөрдөж буй тэмдэг, тэмдэглэгээний талаарх зөвлөмж мэдээллийг өгч ажилласан. Улсын их хурлаас 2020 оны 5 дугаар сард баталж 9 дүгээр сарын 1-ээс мөрдөж эхэлсэн “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс ЕБС болон СӨБ-ын байгууллагуудын хоол үйлдвэрлэлийн газруудын стандартын хэрэгжилт, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, үлдэгдэл хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.	
136		4.2.6 Аймгийн төвд стандартын шаардлага хангасан худалдааны төв байгуулж, хүнсний бүтээгдэхүүнд хяналт үнэлгээ хийх дотоодын лабораторитой болж эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр иргэдийг хангах.	2017-2020	ХОХБТХ, ХХААГ	Хувийн хэвшил-40.0	Дундговь аймгийн Татварын албанд бүртгэлтэй “Номадс Фүүд”, Тогоогийн говь”, “Говийн сор инвест”, “Аргил трейд” ХХК-иуд нь Сайнцагаан сумын 7-р багийн нутагт дэвсгэрт нийт 2,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай 1863м ² талбайтай худалдаа үйлчилгээний төвүүдийг барьж байгуулан 70 гаруй ажлын байрыг бий болгож орчин үеийн шийдэл бүхий стандартын шаардлага хангасан худалдааны төвөөр ард иргэд тогтмол үйлчилгээ үзүүлж байна. Мөн аймгийн төвийн “Тогтох мандал” ХХК-ны хүнсний захын гадна талбайг 40 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварлан стандартын шаардлагын нөхцлийг бүрдүүллээ.	100
137		4.2.7 Ажлын байр шинээр бий болгосон, шинэ нэр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ нээсэн, бүтээгдэхүүнээ гадаад дотоодын зах зээлд нийлүүлж буй бизнес эрхлэгчдийг дэмжих	2017-2020	ХОХБТХ, ХХААГ Сумдын Засаг дарга	СХС-531.0	СХСангаас шинээр үйл ажиллагаа эрхлэх гэж буй 42 бизнес эрхлэгчид 531,0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлд олгогдсон. Шинээр 69 ажлын байр бий болсон байна.	100
138		4.2.8 Дундговьд үйлдвэрлэсэн	2017-			Энэ жил Ковид-19 вирустэй	ҮБ

		бүтээгдэхүүнийг БНХАУ-ын Эрээн хотод борлуулах сурталчлахад дэмжлэг үзүүлэх	2020	ХОХБТХ, ХХААГ,		холбоотой хил дамнасан борлуулалт хийгдэхгүй.	
139		4.2.9 Цагаан-Овоогийн нүүрсний уурхайн сайн боловсрогдоогүй нүүрсийг ашиглаж таван хошуу малын тэжээл хийж Дундговь аймгийн брэнд бүтээгдэхүүн болгох.	2017-2020	ХОХБТХ, ХХААГ,	Хувийн хэвшил-40.0	“Хан дээж” ХХК-ны Малын шингэн тэжээл /Эко тэжээл/-ийн үйлдвэр байгуулах төслийг 2019 онд ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлээс 170 сая төгрөгийг олгуулах дэмжлэг үзүүлснээр “Тэжээлт бор /малын тэжээл/, “Шимт бор” /газар тариалангийн бордоо/ “Хурдан бор” /хурдан морины тэжээл/ гурван нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 5 тн-ыг зах зээлд нийлүүлээд байна. 1 литр бүтээгдэхүүнийг 8000 төгрөгөөр нийт 40 сая төгрөгний борлуулалт хийсэн.	100
140		4.2.10 Орон нутгийн хөрсөнд ургасан хүмүүлийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах үйлдвэр, цех байгуулж хүн амыг экологийн цэвэр хүнсээр хангах санаачлага гаргасан үйлдвэрлэгчийг дэмжих.	2017-2020	ХОХБТХ, ХХААГ, Сумдын Засаг дарга		Өрхийн үйлдвэрлэгчид маань 2020 онд хойш 10 гаруй мянган шил даршилж нийт 50 гаруй сая төгрөгний борлуулалт хийсэн байна. 9 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд зохион байгуулагдах намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд хүнс үйлдвэрлэгч иргэн ААНэгж оролцохоор мэдүүлгээ хүргүүлээд байна.	70

ХЯНАСАН:ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА
НЭГТГЭСЭН: СУРГАЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ж.ШИНЭ-УЯНГА
Ю.ГАНЦЭЦЭГ